



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 35 06, Факс: (976-11) 31 81 69,
Цахим хуудас: www.mmhi.gov.mn


2023.04.06 № 04/848
талай 2022.12.15-ны № 1/669 -т

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНД

Үндэсний геологийн албанаас ирүүлсэн 2022 оны гүйцэтгэлийн тайланд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга болон хянан баталгаажуулсан тайланг хүргүүлж байна.

Хавсралт 40 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Г.БАТБАЯР



1508 05 0704

**ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 03 дүгээр сарын 28-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Үндэсний геологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтыг хүрсэн түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас төсвийн шууд захирагч /Үндэсний геологийн албаны дарга/-тай зөвшилцөн баталсан Үндэсний геологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 23 зорилтын хүрээнд 66 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Үндэсний геологийн албанаас 2022 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.2 дах заалтыг тус тус үндэслэн Үндэсний геологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Үндэсний геологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 зорилго, 23 зорилтын 66 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг 91.2 хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

№	Зорилтын дугаар	Арга хэмжээний тоо		Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо							Үнэлгээ /хувь/
		ХАХ	ТАХ	100	90	70	50	30	0	Бусад	
1.	Зорилт 1.1.	2	2	2							100
2.	Зорилт 1.2.	2	2	2							100
3.	Зорилт 1.3.	1	1	1							100
4.	Зорилт 1.4.	1	1	1							100
5.	Зорилт 1.5.	1	1	1							100
6.	Зорилт 1.6.	1	1	1							100
7.	Зорилт 1.7.	2	2	2							100
8.	Зорилт 1.8.	1	1	1							100
9.	Зорилт 1.9.	3	3	1	2						93.3
10.	Зорилт 2.1.	4	4			2	1		1		47.5
11.	Зорилт 2.2.	2	2	1	1						95.0
12.	Зорилт 3.1.	2	2	2							100
13.	Зорилт 3.2.	10	10	8						1(15.0) 1(98.8)	91.4

14.	Зорилт 3.3.	1	1	1						100	
15.	Зорилт 3.4.	1	1	1						100	
16.	Зорилт 4.1.	2	2			1	1			60.0	
17.	Зорилт 4.2.	3	3	2					1(97.7)	99.2	
18.	Зорилт 5.1.	5	6	1	4		1			85.0	
19.	Зорилт 5.2.	1	1	1						100	
20.	Зорилт 5.3.	5	5	1	1	1	2			72.0	
21.	Зорилт 5.4.	8	8	4	3	1				92.5	
22.	Зорилт 5.5.	3	3		2		1			76.6	
23.	Зорилт 5.6.	4	4	2	1		1			85.0	
Нийт дүн		66	66	36	14	5	7	-	1	3	91.2

Тайлбар: ХАХ-хэрэгжүүлэх арга хэмжээний тоо, ТАХ-тайлагнасан арга хэмжээний тоо

Дөрөв. Дүгнэлт

Үндэсний геологийн алба нь 2022 онд 5 зорилго, 23 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлсэн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт **91.2** хувиар үнэлэгдэв. Үүнээс “үр дүнтэй” 12, “тодорхой үр дүнд хүрсэн” 9 зорилт байна.

Мөн 2.1. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулах Геозкологийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах; 4.1. Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах гэсэн 2 зорилтыг “эрчимжүүлэх шаардлагатай” байна. Биелэлт нь төлөвлөсөн түвшинд хүрээгүй дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг сайжруулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах нь зүйтэй байна.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.2 дах заалтыг үндэслэн Үндэсний геологийн албаны 2022 оны гүйцэтгэлийн тайланд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж холбогдох санал, зөвлөмжийг тус албанд хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар тайлагнахдаа дээрх санал, зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох засварыг хийж ирүүлсэн байна.

Тав. Санал, зөвлөмж

- Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа үйл явцыг дэлгэрэнгүй тоочилгүй, үр дүнг товч, тодорхой бичиж, тайлангийн чанар, утга найруулгыг хянаж, нотлох баримт буюу холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг дурдах,
- Төсвийн ерөнхийлөн захирагч /Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд/-аас төсвийн шууд захирагч /Үндэсний геологийн албаны дарга/-тай зөвшилцөн баталсан төлөвлөгөөнд туссан шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшингийн дагуу хэрэгжилтийг үнэн зөв тайлагнах,
Тодруулбал, 1.6.1; 2.1.2; 3.2.5; 3.2.7; 3.2.8; 5.1.1; 5.1.6 дах арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин батлагдсан төлөвлөгөөнөөс зөрүүтэй тайлагнаж ирүүлсэн байна.
- Арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлсэн хэдий ч ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх нь тодорхойгүй, тайлагнасан байдал хангалтгүй

байтал "үр дүнтэй" буюу 100 хувиар үнэлсэн нь учир дутагдалтай байна. Иймд хяналт-шинжилгээ, үнэлгээг бодитой буюу Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.1 болон 6.2.2-т заасан аргачлалын дагуу хийх;

Тухайлбал, "2.1.1. Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн бүс болон ашигт малтмалын сонирхолтой хэсгүүдэд улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил гүйцэтгэн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх" арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг "хэрэгжүүлсэн төслийн тоо", зорилтот түвшинг "7" гэж тодорхойлсон байна. Гэтэл тус арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа орд, илрэлийн байршлын зураг, дагалдах мэдээллүүдийн танилцуулгыг хүргүүлж, сайдад танилцуулсан гэсэн бөгөөд төсөл хэрэгжүүлсэн талаар дурдаагүй байна. Иймд цаашид зорилт, арга хэмжээг хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг илэрхийлсэн, бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан байдлаар төлөвлөж, хийж гүйцэтгэсэн ажлыг бүрэн гүйцэд тайлагнаж, зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг, зорилтот түвшинтэй харьцуулах замаар хэрэгжилтийг үнэн, зөв, бодитой үнэлэх;

- Зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зорилтод, цаашлаад зорилгод чиглэсэн байх гэсэн нийтлэг шаардлагын дагуу арга хэмжээг тодорхойлох;
- Тухайн зорилт, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэх талаар тодорхой тайлагнах.

Хянасан:

ХШҮДАГ-ын ЦБМТХ-ийн дарга

Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргасан:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн *Н. Энхсайхан*

Ж.Энхсайхан

Дахин үнэлгээ хийсэн

ХШҮДАГ-ын ахлах шинжээч

Х.Цэнд-Аюуш
Х.Цэнд-Аюуш



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайланг хянасан:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
(албан тушаал)

Тэмдэг



Төсвийн Ерөнхийлөн захирагч

М. Дорж
(гарын үсэг)


/Жамбалын Ганбаатар/

(огноо)

Гүйцэтгэлийг тайлагнасан:

Үндэсний геологийн албаны дарга
(албан тушаал)

Тэмдэг



Төсвийн Шууд захирагч

Ойдовын Чулуун
(гарын үсэг)

/Ойдовын Чулуун/

(огноо)

2022.12.15

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	№	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /ЗГҮАХ-АХТ/ Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Үндэсний геологийн албаны стратеги төлөвлөгөө (2020-2024).	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Үнэлгээ /хувь/	
								ҮГА	УУХҮЯ
ЗОРИЛГО 1. Улсын төсвийн хөрөнгөөр нутаг дэвсгэрийн геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологи, геотехникийн зэрэг зураглал, судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттай төлөвлөх, гүйцэтгэх, удирдах									
Зорилт 1.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /ЗГҮАХ/ 3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.									
1.	1.1.1	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй геологийн судалгааны ажлуудын нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 5-ны дотор УУХҮЯ-нд хүргүүлэх	-	Тайлангийн тоо	0	4	1. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 30, сэдэвчилсэн судалгааны 7, нийт 37 төслийн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, үр дүнг нэгтгэн, 70 гаруй хуудас бүхий 2021 оны нэгдсэн тайланг гаргаж, 2022.01.11-ний өдрийн 1/11 дүгээр албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. 2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 20, сэдэвчилсэн судалгааны ажлын 9 нийт 29 төслөөс ирүүлсэн 2022 оны 1 дүгээр улирлын тайланг хүлээн авч хянаж, үр дүнг нэгтгэн, танилцуулга, дүгнэлт бүхий 56 хуудас нэгдсэн тайланг гаргаж, 2022.06.08-ны өдрийн 1/331 дүгээр албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. 3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 22, сэдэвчилсэн судалгааны 13, нийт 35 төслийн 2 дугаар улиралд тайланг хүлээн авч, ажлын явц,	100%	100%

							үр дүнг төсөл бүрээр нь нэгтгэн, 39 хуудас бүхий нэгдсэн тайланг бэлтгэж, 2022.07.28-ны өдрийн 1/409 дүгээр албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн. 4. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 32, сэдэвчилсэн судалгааны ажлын 9, нийт 41 төслийн 2022 оны 3 дугаар улирлын тайланг хүлээн авч, үр дүн, тоо, хэмжээг Excel программаар нэгтгэж файлыг УУХҮЯ-ны ахлах шинжээч Х.Санчигдоржийн хүсэлтийн дагуу JPG файл хэлбэрээр sanchigdorj@mmhi.gov.mn болон Able онлайн системээр илгээсэн. 5. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны төслүүдийн 2022 жилийн эцсийн тайланг хүлээн авч, ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянан, нэгтгэсэн. /Тайланг хуулийн хугацаанд хүргүүлэхэд бэлэн болсон/.		
2.	1.1.2	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн сар бүрийн гүйцэтгэлийг хянаж, дараа сарын 5-ны дотор УУХҮЯ-нд хүргүүлэх	-	Хянасан гүйцэтгэл 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэж буй төслүүдээс 1 дүгээр сард 32, 2 дугаар сард 33, 3 дугаар сард 35, 4 дүгээр сард 35, 5 дугаар сард 32, 6 дугаар сард 35, 7 дугаар сард 39, 8 дугаар сард, 9 дүгээр сард 29, 10 дугаар сард 35, 11 дүгээр сард 41, 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэл болох 12 төслийн гүйцэтгэлийг тус тус хүлээн авч, геологи, геохимийн ажлын тоо хэмжээ, арга аргачлалыг хянаж, нэгтгэн УУХҮЯ-нд хүргүүлэхээр Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн Нормчлол, санхүүжилт хариуцсан мэргэжилтэнд FinanceCHECK цахим системээр болон батлагдсан маягтын дагуу цаасан баримтаар гарын үсгээр албажуулан илгээсэн. /УУХҮЯ-нд илгээсэн огноо болон албан тоот нь тус тайлангийн 2.2.1 тусгагдсан болно. 12 удаагийн албан бичгээр/.	100%	100%
Зорилт 1.2. ЗГҮАХ-АХТ 3.2.3.1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулах									
3.	1.2.1	Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр эхлүүлэх нийт 8 төслийн геологийн	-	Төслийн тоо	0	8	1. Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд шинээр төсөл эхлүүлэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа-2050 болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, бүс	100%	100%

		даалгаврын төслийг боловсруулах, ажлыг эхлүүлж, эхлэлийн тайланг хүлээн авах					нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн геологийн тогтцыг нарийвчлан судлах, металлогений муж, бүс, голлох хүдрийн дүүрэг, зангилаануудыг бүрхэж, орд, илрэлүүдийг нээн илрүүлэх боломж, зарчмыг баримтлан 1. Үүрэг нуур-50, 2. Мөст уул-50, 3. Ямбат уул-50, 4. Овоот шар-50, 5. Ханхар уул-50, 6. Баянзүрх уул-50 төслүүдийн геологийн даалгаврыг боловсруулж батлуулсан. 2. Сэдэвчилсэн судалгааны 7. Гео-Орчин, 8. Баруун Монголын техтоник, шатах ашигт малтмалын судалгаа, төслүүдийн геологийн даалгаврын төслийг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайдаар батлуулж, Үндэсний геологийн албатай гэрээг байгуулж, урьдчилсан хэлэлцүүлэг хийж, төлөвлөгөөг гарган, төслүүдийн хээрийн үйлдвэрлэлийн ажлуудыг эхлүүлсэн.		
4.	1.2.2	Хэрэгжиж буй төслүүдийн хээрийн үйлдвэрлэлийн явцад шуурхай хяналт хийх, арга аргачлалд зөвлөгөө өгөх, хээрийн материал хүлээж авах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	24	1. Борзонгийн говь-50, Буйлст хүрэн уул-50, Бөөн хөх уул-50, Ямаат уул-50 төслүүдэд 2022.08.01-12-ны өдрүүдэд, 2. Үнэгт уул-50, Их хараат уул-50, Дөч гол-50, Загал уул-50 төслүүдэд 2022.08.27-09.07-ны өдрүүдэд, 3. Уушгийн улаан-50, Улаангом-50, Торлог Уул-50, Хар хайрхан-50 төслүүдэд 2022.08.03-16-ны өдрүүдэд, 4. Ямбат уул-50, Овоот шар-50, Ховд-геозкологи, Үүрэг нуур-50, ӨТТЭ-1 төслүүдэд 2022.08.29-09.13-ны өдрүүдэд, 5. Гилбэнт уул-50, Зангат-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50 төслүүдэд 2022.09.09-22-ны өдрүүдэд, 6. Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Их бэрх уул-50, Мөст Уул-50 төслүүдэд 2022.08.25-09.03-ны өдрүүдэд,	100%	100%

							7. Дархан геоэкологи, Гүний хагарал, УГЗ-200-М нэгтгэл, Баянзүрх-50 төслүүдэд 2022.08.03-12-ны өдрүүдэд, 8. Мезой-Кайнозой, Эрэл үнэлгээ-2 төслүүдэд 2022.08.12-14-ний өдрүүдэд нийт 31 төслийн 2022 оны хээрийн үйлдвэрлэлийн ажил, завсрын суурин боловсруулалт, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулах, хэмжилт, хяналт хийх, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж ажилласан болно. 9. 2022.11.07-30-ны хооронд УУХҮЯ, мэргэжлийн холбоодын төлөөллийн хамт нийт 43 төслийн хээрийн материалыг хүлээн авч, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж ажилласан болно.		
Зорилт 1.3. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100% хамруулах									
5.	1.3.1	Монгол орны нутаг дэвсгэрт хийгдэх 1:1000000-ын масштабын геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны төсөлд тайлангийн шуурхай хяналтыг хийх, хээрийн материалыг хүлээн авах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	1:1000000-ын масштабын геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх судалгааны төслийн үр дүнгийн тайлангийн эцсийн суурин боловсруулалтын явцад шуурхай хяналтыг 2022.06.21-ний өдөр хийж, үр дүнгийн тайлан боловсруулалтын явц, хэрэгжилт, ажлын чанар, үр дүн, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. 2022.11.11-ний өдөр төслийн тайлан боловсруулалтын ажлын явцтай танилцан, хээрийн материалыг хүлээн авсан болно.	100%	100%
Зорилт 1.4. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.7.Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх									
6.	1.4.1	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх сэдэвчилсэн судалгааны "БМШАМ-2022" төслийн ажлыг шинээр эхлүүлж, суурь геологийн нөхцөл байдлын хүрээнд эхлэлийн тайланг хүлээж авах, шуурхай хяналт хийх, хээрийн материалыг хүлээн авах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа БМШАМ төслийн шуурхай хяналт хийж, хээрийн материал хүлээн авч, мэргэжлийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргасан. Үүнд: Анхдагч баримт материалын зургийг 1:500000-ны масштабаар нэгтгэж, нэгдсэн таних тэмдгийн хамт зохиох. 1. "Судалт мана" ХХК-ийн гүйцэтгэж буй БМШАМ-2022 төслийн 2022 оны хээрийн материалыг тус протоколыг дагасан акт /хавсралт 1-8/-уудын дагуу хүлээн авах. 2. Хээрийн материалыг 253,928,981 төгрөгөөр хүлээн авч, санхүүжүүлэхийг Үндэсний геологийн албаны удирдлагад уламжлах.	100%	100%

							Тус төслийн хээрийн материал хүлээж авсан тухай хурлын тэмдэглэл дагалдах актуудыг бүрдүүлж, хүлээн авсан. Нийт төслүүдийн хамт тус нэгтгэлийг гаргаж, УУХҮЯ-нд албан бичгээр хүргүүлсэн болно.		
Зорилт 1.5. Бараа тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэх тохиолдолд мэдүүлэгч нь гаалийн удирдах төв байгууллагад хүсэлтээ гаргах бөгөөд түүнд холбогдох байгууллагын зөвшөөрөл, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг хавсаргах									
7.	1.5.1	“Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох” зааврын дагуу геологичайгуулын болон бусад холбогдох судалгаа шинжилгээний ажлын хүрээнд гадаад орнуудад шинжилгээ хийлгэх дээжид тодорхойлолт олгох, мэдээллийн сан хөтлөх	-	Тодорхойлолтын тоо	10	20	“Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох” зааврын дагуу Шинжлэх ухаан технологийн сургуулийн 13, Шинжлэх ухааны академийн Геологийн хүрээлэнгийн 1, Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн 3, Монгол Улсын их сургуулийн 2, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 1, “Минторес” ХХК-ийн 1, Шинжлэх ухааны академийн төслийн 1 нийт 22 тодорхойлолт боловсруулж, албан бичгээр илгээж, хилээр нэвтэрсэн 22 хүсэлтийн сорьцын мэдээллийг санд бүртгэсэн.	100%	100%
Зорилт 1.6. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх жил бүрийн геологийн судалгааны ажлын төлөвлөгөө, төсөл, төсвийг батлах, тодотгох, үр дүнгийн тайланг хүлээн авсан тухай шийдвэр гаргах									
8.	1.6.1	2017-2022 онд дуусах L төслүүдийн эцсийн үр дүнг нягталж, тайлан нэгтгэлд заавар, зөвлөгөө өгч, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, үр дүн, гүйцэтгэлд суурилсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	-	Бэлтгэл хангагдсан тайлан, төсөв, төлөвлөгөөний тодотгол хэлэлцүүлсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	УГЗ-200-L лист нэгтгэл төсөлд 2022.01.21-ний өдөр зохион байгуулж, геологийн судалгааны ажлын үр дүн, чанар, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга замуудын талаар илтгэл, хэлэлцүүлэг хийж, хурлаас санал, зөвлөмж, дүгнэлт гаргаж ажилласан. Тус төслийн 2022 оны геологи судалгааны ажлын төлөвлөлт, арга, аргачлалд, төсвийг хянаж мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар төслийн төсвийн тодотголыг хэлэлцүүлж төсөв, төлөвлөгөөг бүрэн батлуулсан.	100%	100%
Зорилт 1.7. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын их бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулах									
9.	1.7.1	УГЗ-200 L нэгтгэл төслийн тайлан боловсруулалтын ажлын явц, үр дүнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	Улсын геологийн зураг нэгтгэх УГЗ-200-L төслийн үр дүнгийн тайлангийн эцсийн суурин боловсруулалтын явцад шуурхай хяналтыг 2022.06.20-ны өдөр хийж, үр дүнгийн тайлан боловсруулалтын явц, хэрэгжилт, ажлын чанар, үр дүн, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. 2022.11.08-ны өдөр төслийн тайлан боловсруулалтын ажлын явцтай танилцан хээрийн материалыг хүлээн авч,	100%	100%

							мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан		
10.	1.7.2	УГЗ-200 М нэгтгэл төслийн хээрийн үйлдвэрлэлийн хээрийн материалыг хүлээн авах, газар дээр нь мэргэжлийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	УГЗ-200 М нэгтгэл төсөлд 2022.08.03-12-ны өдрүүдэд хээрийн үйлдвэрлэлийн явцад шуурхай хяналт хийж, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг газар дээр нь баталгаажуулах, хэмжилт, хяналт хийх, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан. Мөн 2022.11.21-ний өдөр тус төслийн хээрийн материалыг хүлээн авсан болно.	100%	100%
Зорилт 1.8. ЗГҮАХХ-АХТ 3.2.3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулах									
11.	1.8.1	Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн хэрэгжилтийг хангах, ажлын гүйцэтгэл үр дүнд шуурхай хяналт хийх, хээрийн материалыг хүлээн авах, газар дээр нь мэргэжлийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Ховд-1" төслийн сар бүрийн гүйцэтгэл, ажлын тоо хэмжээ, чанар, үр дүнд хяналт хийж, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангаж, холбогдох дүгнэлтийг гаргасан ба хээрийн материалыг 2022.11.18-ны өдөр хүлээн авсан болно.	100%	100%
Зорилт 1.9. ЗГҮАХ-АХТ 3.2.3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажил хийх									
12.	1.9.1	Хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгааны "Дархан, Ховд, Сайншанд", Гүний хагарал-1, Гео-Орчин 2022 төслийн хэрэгжилтийг хангах, ажлын гүйцэтгэл үр дүнд шуурхай хяналт хийх, хээрийн материалыг хүлээн авах, газар дээр нь мэргэжлийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	5	Сэдэвчилсэн судалгааны Да-геоэкологи, Гүний хагарал төслүүдэд 2022.08.03-12-ны өдрүүдэд, Ховд геоэкологи, ӨТТЭ-1 төслүүдэд 2022.08.29-09.13-ны өдрүүдэд хээрийн үйлдвэрлэлийн явцад шуурхай хяналт хийж, сар бүрийн ирүүлсэн гүйцэтгэлийг баталгаажуулах, судалгааны ажлын чанар, үр дүнд дүгнэлт өгч газар дээр нь хэмжилт, хяналт хийж ажилласан. Сайншанд геоэкологи, гидрогеологийн судалгаа төслийг УУХҮЯ-наас улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны ажилд тус төслийг санхүүжүүлэх зардлыг УУХҮЯ-наас төсөвт суулгаагүй болно. /Ямнаас гарсан шийдвэр тул/. Орчин-2022 төсөлд хэлэлцүүлэг зохион байгуулж, эхлэлийн тайланг хүлээн авч, хээрийн үйлдвэрлэлийн ажлыг эхлүүлсэн. Дээрх төслүүдийн 2022 оны хээрийн материалыг 2022.11.16-30-ны өдрүүдэд хүлээн авсан.	100%	90%

13.	1.9.2	Эрдэнэт геоэкологи төслийн тайлан боловсруулалтын ажлын явц, үр дүнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	1	Тус төслийн тайлан редакцын гишүүдээр хянагдаж засвар хийгдсэн мөн шүүмжлэгч проф М.Алей, зөвлөх геологич Б.Мөнхцэнгэл нарын шүүмжид засвар, хариу тайлбар хийгдсэн ба Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан болно.	90%	90%
14.	1.9.3	2022 онд шинээр эхлэх төслүүд (Гео-Орчин 2022, Сайншанд геоэкологи)-ийн геологийн даалгавар боловсруулах	-	Геологийн даалгавар боловсруулах төслийн тоо	0	2	2022 онд шинээр хэрэгжүүлэх 1. "Гео-Орчин-2022", 2. "Сайншанд хотын геоэкологи-гидрогеологи", 3. "Монгол орны алтны металлогений судалгаа" төслүүдийн геологийн даалгаврыг боловсруулсан ба УУХҮЯ-нд цахим /sanchigdorj@mmhi.gov.mn/ хаягаар хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар "Гео-Орчин-2022", "Монгол орны алтны металлогений судалгаа" төслүүдэд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулахаар үнэлгээний хороон дээр тендер шалгаруулалтын ажил явагдаж байна.	100%	100%
ЗОРИЛГО 2. Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений суурь судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бүс, зангилгаа, талбайг ялгах ажлыг зохион байгуулах									
Зорилт 2.1. Шинэ сэргээлтийн бодлого-3.1.2, ЗГҮАХ-3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулах									
15.	2.1.1	Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн бүс болон ашигт малтмалын сонирхолтой хэсгүүдэд улсын төсвийн хөрөнгөөр геологи-хайгуулын ажил гүйцэтгэн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх	-	Хэрэгжүүлсэн төслийн тоо	1	7	Монгол Алтайн нуруу болон Алтайн цаадах говийн Улсын тусгай хамгаалалттай газар, хилийн бүсэд хамаарагдах 1.Талын мэлтэс 2.Хатан суудал 3.Халтар Уул-1 4.Халтар уул-2 5.Бүдүүн 6.Нүхэний нуруу 7.Эрэн уул нэртэй алтны орд, илрэлийн байршлын зураг дагалдах мэдээллүүдийг гаргаж, УУХҮСайд асан Г.Ёндонд хүргүүлсэн. Сайдад Үндэсний геологийн албаны дарга О.Чулуун 2022 оны 03 дугаар сард биечлэн танилцуулга хийсэн. УУХҮСайд Ж.Ганбаатарт 2022.12.13-ны өдрийн албан бичгээр улсын тусгай хамгаалалттай болон хилийн бүсэд орших хэтийн төлөв бүхий талбайд улсын төсвийн хөрөнгөөр геологи-	100%	0%

							хайгуулын ажил гүйцэтгэх талаарх танилцуулгыг хургуулсан.		
16.	2.1.2	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгааны төслүүдэд шуурхай хяналт хийх, хээрийн материал хүлээн авах, мэргэжлийн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргах	-	Хяналт хийсэн төслийн тоо	0	8	ЭБСТЭЗХэлтсээс Сүхбаатар аймгийн Түвшинширээ сум, Дорнод аймгийн Дашбалбар сумдын нутагт "Геосигналс" ХХК-ийн гүйцэтгэж байгаа Эрэл үнэлгээ-3 төсөлд хээрийн шуурхай хяналтыг 2022.08.22-09.04-ний хооронд хийж, гүйцэтгэн ажлын арга аргачлал, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, дараах шийдвэрийг гаргаж ажилласан. Үүнд: 1. Байрзүйн зургийн ажил гүйцэтгүүлсэнтэй холбоотой ажлын гэрээ, ажил гүйцэтгэсэн тухай актыг ажлын 10 хоногт багтааж үзүүлэх; Төсөл гүйцэтгэж байгаа инженер техникийн албан хаагчид солигдсан байна. Албан бичгээр ҮГА-нд мэдэгдэхийг "Геосигналс" ХХК-ийн захирал Г.Өгөөмөрт үүрэг болгох; 2022 оны 08 дугаар сарын байдлаар гүйцэтгэлд оруулсан 1,2 тэрбум төгрөгийн анхан шатны баримт, дээж тушаасан захиалгын хуудас, нэхэмжлэхийг ажлын 10 хоногт багтаан үзүүлэх; Анхдагч баримт материалын бүрдүүлэлтийг цаг тухай бүрд нь баримтжуулах; Анхдагч баримт материалын жагсаалтыг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар хүлээн авч, зөвшөөрөх; Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг цаашдын ажилдаа мөрдлөг болгон ажиллах зөвлөмж өгсөн. 2. 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга сумдын нутагт "Геологийн судалгааны төв"-ийн гүйцэтгэж байгаа Эрэл үнэлгээ-4 төслийн ажлыг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022.09.19-2022.10.02-ны хооронд хийж гүйцэтгэн ажлын арга аргачлал, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж дараах шийдвэрийг гаргаж ажилласан. Үүнд: Тендерт шалгарсан бүрэлдэхүүнээс 11 голлох мэргэжилтэн солигдсон байх тул ҮГА-нд албан бичгээр хандан шийдвэрлүүлэхийг ГСТ-ийн захирал Н.Ганболд-/д/ үүрэг болгох; Анхдагч литогеохимийн сорьцолтын 4664 ш дээжийн зардал болох 58,300,000 төгрөгийг	100%	50%

						хоёрдогч литогеохимийн сорьцлолт руу шилжүүлэхийг зөвшөөрч удирдлагад уламжлах; Шуурхай хяналтын бүрдүүлэх материалыг хавсралт 1,2,3 дугаараар хүлээн авч, зөвшөөрөх; Комиссын гишүүдээс өгсөн үүрэг, даалгавар зөвлөмжийг цаашдын ажилд мөрдлөг болгон ажиллах; Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг цаашдын ажилдаа мөрдлөг болгон ажиллах. 3. Баян-өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгийн нутагт “Судалт мана” ХХК-ийн гүйцэтгэж байгаа Баруун Монголын зарим бүс (Монгол Алтай, Нууруудын хотгор, Төв Монголын массив)-ийн тектоник ба шатах ашигт малтмалын хэтийн төлөв төслүүдэд хээрийн шуурхай хяналтыг 2022.09.19-10.02-ны хооронд хийж гүйцэтгэн ажлын арга аргачлал, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, дараах шийдвэрийг гаргаж ажилласан. Үүнд: “Судалт мана” ХХК-ийн “БМШАМ”-ын төслийн ажлыг батлагдсан төлөвлөгөө арга аргачлалын дагуу гүйцэтгэсэн гэж үзэж, 2022.09.20-ны байдлаар ажил гүйцэтгэлийн өртөг 85,160,005 төгрөгийг хүлээн авч, санхүүжүүлэх; “БМШАМ”-ын төслийн 2022 оны хээрийн үйлдвэрлэлийн ажлын шалгуулсан материалын жагсаалтыг хавсралт 1 дүгээр, бүрдүүлсэн анхдагч материалын жагсаалтыг 2 дугаар, төслийн ИТА-ын жагсаалтыг хавсралт 3 дугаар хавсралтаар хүлээн авч, зөвшөөрөх; Хээрийн материал авах үед МУИС-ийн багш нарын 8 болон 9 сард хийгдсэн суурин боловсруулалтын ажлыг болон хээр ажилласан үеийн хээрийн тэмдэглэлийн дэвтрийг шалгуулах; Комиссын гишүүдээс өгсөн санал, зөвлөмжийг мөрдөж ажиллахыг “Судалт мана” ХХК-ийн захирал /Ч.Алтанзул/, төслийн нийт бүрэлдэхүүнд үүрэг болгох; Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгааны дараах төслүүдийн хээрийн материалыг комиссын гишүүд дараах шийдвэрийг гаргаж хүлээн авсан:		
--	--	--	--	--	--	--	--	--

						Төв ази 3D 5-р үе шат: Геологийн судалгааны төвийн “Хойт, Төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” V үе шатны төслийн 2022 хээрийн ажил, завсрын суурин боловсруулалтын үед бүрдүүлсэн анхдагч материалыг хүлээгдэж буй гүйцэтгэлийн хамт хавсралт (№1-7)-аар хүлээн авах. Энэхүү тэмдэглэлийн хавсралт (№1-7)-р хүлээн авсан ажлын гүйцэтгэл болон 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн хамт 245,600,687 (хоёр зуун дөчин таван сая зургаан зуун мянга зургаан зуун наян долоо) төгрөгөөр санхүүжүүлэхийг зөвшөөрөх. Төслийн ерөнхий координаторын асуудлыг албан шугамаар захиалагч УУХҮЯ болон ҮГА-нд хандан шийдвэрлүүлэх. ӨТТЭ-1: “Геологийн Судалгааны Төв” (ТӨҮГ)-ийн гүйцэтгэж буй ӨТТЭ-1 төслийн 2022 оны судалгааны ажлын бүрдүүлсэн анхдагч баримт материалын хэмжээнд /Хавсралт 1–4 дүгээрт тусгасан бүртгэл, тоо хэмжээ, дүнтэйгээр/ хүлээн авах; ӨТТЭ-1 төслийн анхдагч баримт материалыг хүлээн авсантай уялдуулан 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн хэмжээнд 556,158,229 /таван зуун тавин зургаа сая нэг зуун тавин найман мянга хоёр зуун хорин ес/ төгрөгөөр санхүүжүүлэх /Хавсралт 3/. Багийн бүрэлдэхүүний 60% нь өөрчлөгдсөн байх тул ҮГА-нд албан тоотоор мэдэгдэхийг “Геологийн Судалгааны Төв” (ТӨҮГ)-ийн захиралд үүрэг болгох Комиссын гишүүдээс өгсөн санал, зөвлөмж, үүрэг даалгаврыг цаашид анхаарч ажиллах. ӨТТЭ-2: Улирлын тайлан мэдээг хугацаанд гаргаж байх; Сар бүрийн гүйцэтгэлийг үнэн зөв гаргах; Инженер техникийн ажилчид солигдсоныг Үндэсний геологийн албанд албан тоотоор солигдсон хүмүүсийн мэдээллийг өгөх; ӨТТЭ-2 төслийн 2022 оны давсан гүйцэтгэлийг хавсралт №1-9 ийн дагуу хүлээж авах;		
--	--	--	--	--	--	--	--	--

						ӨТТЭ-2 төслийн 2022 оны гүйцэтгэлийг 413,518,249.00 төгрөгөөр хүлээж авах; Комиссын гишүүдээс өгсөн санал, зөвлөмж, үүрэг даалгаврыг цаашид анхаарч ажиллах. Эрэл үнэлгээ-2: Хээрийн анхдагч баримт материалыг хавсралт АББД № (1.1-1.4, 2.1, 3.1-3.3, 4.1-4.3, 5.1-5.3, 6.1, 7.1-7.3, 8.1-8.3, 9.1-9.3, 10.1-10.3, 11.1-11.9, 12.1-12.22, 13.1, 14.14)-р хүлээн авах. Төслийн 2022 оны хээрийн анхдагч материал хүлээн авсантай уялдуулан төслийн ажлын 2022 оны 2,366,667,591 (хоёр тэрбум гурван зуун жаран зургаан сая зургаан зуун жаран долоон мянга таван зуун ерэн нэгэн) төгрөгийн гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрч санхүүжүүлэх. Ажлын хэсгээс өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг мөрдөж ажиллахыг төслийн бүрэлдэхүүнд үүрэг болгох. Эрэл үнэлгээ-3: 2022 оны геологийн судалгааны ажлын хээрийн материалыг 3,422,584,606 төгрөгөөр хүлээж авах. Анхдагч баримт материалын жагсаалтыг хавсралт 1,2,3,4-өөр хүлээн авч, зөвшөөрөх. Суурин боловсруулалтын ажлыг чанартай сайн гүйцэтгэхэд анхаарч ажиллах. Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг цаашдын ажилдаа мөрдлөг болгон ажиллах. Эрэл үнэлгээ-4: Тендерт шалгарсан бүрэлдэхүүнээс 11 голлох мэргэжилтэн солигдсон байх тул УГА-нд албан бичгээр хандан шийдвэрлүүлэхийг ГСТ-ийн захирал Н.Ганболд-/д/ үүрэг болгох. “Эрэл-үнэлгээ 4” төслийн 2022 оны хээрийн ажлыг 748,303,724 төгрөгөөр хүлээн авах. Хээрийн материалыг 1,2,3 дугаар хавсралтаар хүлээн авч, зөвшөөрөх. Комиссын гишүүдээс өгсөн үүрэг, даалгавар зөвлөмжийг цаашдын ажилд мөрдлөг болгон ажиллах.		
--	--	--	--	--	--	--	--	--

							Илүү хийгдсэн дээжлэлт болон лабораторийн шинжилгээний ажлын зардал болох 311,451,224 төгрөгийг санхүүжүүлэх асуудлыг удирдлагад танилцуулж уламжлах. Мета-алт: Тендерт шалгарсан инженер, техникийн ажилчид солигдвол Үндэсний геологийн албанд албан бичгээр хандан шийдвэрлүүлэх. "Магнетик Сурвей" ХХК-ний Захирал Ж.Отгонцэцэгт үүрэг болгох. Хээрийн материалыг 1,2,3,4 дугаар хавсралтаар хүлээн авч, зөвшөөрөх. 2022 оны хээрийн ажлын төлөвлөгөөнөөс илүү хийгдсэн эталон дээж 3ш, цэглэн 17ш, ховил 7ш, аншлиф, шлиф 25ш буюу 351100 төгрөгний ажлыг санхүүжүүлэх асуудлыг удирдлагуудад танилцуулах. Мета-Алт-500 төслийн 2022 оны хээрийн ажлыг 497,124,872 төгрөгийн санхүүгээр хүлээн авах. Комиссын гишүүдийн үүрэг, даалгавар зөвлөмжийг үүрэг болгон ажиллах. БМШАМ: Анхдагч баримт материалын зургийг 1:500000-ны масштабаар нэгтгэж, нэгдсэн таних тэмдэгийн хамт зохиох. "Судалтмана"ХХК-ийн гүйцэтгэж буй БМШАМ-2022 төслийн 2022 оны хээрийн материалыг тус протоколыг дагасан акт /хавсралт 1-8/-уудын дагуу хүлээн авах Хээрийн материалыг 253,928,981 төгрөгөөр хүлээн авч санхүүжүүлэхийг ҮГА-ны удирдлагад уламжлах. Төслүүдийн хээрийн материал хүлээж авсан тухай хурлын тэмдэглэл дагалдах актуудыг бүрдүүлж хүлээн авсан. Мөн тухайн төслүүдийн нэгтгэлийг гаргаж УУХҮЯ-нд хүргүүлсэн.		
17.	2.1.3	Ашигт малтмалын орд, нөөцийн улсын тоо бүртгэл хөтлөх, Нөөцийн тоо бүртгэл хөтлөх ажлын явцад гүйцэтгэл хоорондын	-	Нөөцийн тоо бүртгэл	0	20	ЭБМЗ-өөр 2022 онд хэлэлцсэн ашигт малтмалын ордын тодотгол нөөцийн 20 тайлангийн нөөцийг ашигт малтмалын санд бүртгэн хүлээн авах тушаал гаргасан. Төмрийн нөөцийн баланс 2010-2021 оны байдлаар гаргасан.	90%	70%

		уялдаа холбоотой үүсч буй асуудлуудыг шийдвэрлэх, сайжруулах.					Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Ашигт малтмалын ордын улсын данс хөтөлж, ашигт малтмалын нөөцийн улсын баланс зохиох зааврыг хийх ажлын дагуу ажлын хэсэг байгуулж ажилласны үр дүнд BGR төсөлд санал болгож, тохирсны дагуу төслөөс санхүүжүүлэн олон улсын зааварт нийцүүлэн гүйцэтгэхээр УУХҮЯ, Үндэсний геологийн алба, Ашигт малтмал, газрын тосны газраас нөөцийн баланс хөтлөх зааварт хамтран ажиллах санал чиглэл авахаар яаманд албан тоот илгээхээр бэлтгэн, удирдлагад танилцуулсан. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Гео шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэнтэй хамтран ажиллах төслийн хүрээнд дэмжиж ажиллаж экспертүүдийг төслөөс цалинжуулах санал гаргаж, дэмжигдэн ажиллаж байна. Ийнхүү нөөцийн тоо бүртгэл хөтлөх ажлын явцад гүйцэтгэл хоорондын уялдаа холбоотой үүсч буй асуудлууд шийдвэрлэгдсэн.		
18.	2.1.4	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар эцсийн үр дүнгийн тайланг хэлэлцүүлэн хүлээж авсан судалгааны төслүүдийн гэрээ дүгнэх актын төслийг боловсруулан УУХҮЯ-нд хүргүүлэх	-	Гэрээ дүгнэсэн акт: 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	Номгоны нуруу-50, УГЗ-200 нэгтгэл-К, Худгийн нуруу-50, Олон гол-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Шүтээн улаан уул-50, Бүрхтэй уул-50 нийт 9 төслийн гэрээний хэрэгжилтийг хянаж, гэрээ дүгнэсэн актын төсөлд хавсаргах төсвийн нэгдсэн гүйцэтгэлийг хянаж, гэрээ дүгнэсэн актыг албажуулав.	100%	70%
Зорилт 2.2. ЗГҮАХ-АХТ 3.2.3 Улсын төсвийн хөрөнгөөр явуулж байгаа үйл ажиллагааг эрхлэх, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажилд хяналт тавих, тайланг хүлээн авч хянах, холбогдох дүгнэлт гаргах замаар геологийн судалгааны ажлыг удирдан чиглүүлэх									
19.	2.2.1	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэл, зарцуулалтыг хянаж, нэгтгэн УУХҮЯ, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх	-	Сар бүр хүргүүлсэн байх	0	12	Сар бүрийн гүйцэтгэлийг хүлээн авч, зарцуулалтыг хянаж, нэгтгэн, Үндэсний статистикийн хороонд 2022.02.08-ны 5/49, 2022.03.04-ний 5/97, 2022.04.06-ны 5/176, 2022.05.04-ний 5/234, 2022.06.06-ны 5/324, 2022.07.07-ны 5/378, 2022.08.10-ны 5/453, 2022.09.01-ний 5/488, 2022.10.05-ны 5/549, 2022.11.04-ний 5/601, 2022.12.08-ны 5/652 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	100%	90%

20.	2.2.2	Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд шинээр эхлүүлэх эрдэс баялгийн чиглэлийн сэдэвчилсэн судалгааны төслүүдийн төлөвлөлтийн санал, геологийн даалгаврын төслийг боловсруулж, танилцуулга, холбогдох материалын хамт УУХҮЯ-нд хүргүүлэх	-	Төслийн тоо	0	4	Эрдэс баялгийн сэдэвчилсэн судалгааны 1.Эрэл үнэлгээ-4, 2.Баруун монголын шатах ашигт малтмал-2022, 3.Өндөр технологийн түүхий эд-II, 4.Мета-алт-500 геологийн даалгавар болон холбогдох материалыг 2021.12.27-ны өдрийн 1/413 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд хүргүүлсэн.	100%	100%
ЗОРИЛГО 3. Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах									
Зорилт 3.1. ЗГҮАХ 3.2.4, Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 3 дугаар зорилт. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.									
21.	3.1.1	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн цахим санг /ҮГЭБМНЦС/ баяжуулж, боловсруулах	-	Баяжуулж боловсруулсан мэдээллийн тоо	0	50	Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн - ҮГЭБМНЦС-ийн илрэлийн санг 278 өгөгдлөөр баяжуулж боловсруулсан. Мэдээлэл үзэх сайт: www.mris.mn	100%	100%
22.	3.1.2	Давхарга зүйн сан, Интрузив чулуулгийн сан, Эффузив чулуулгийн сан, Палеонтологийн олдворын дэд сан, Үнэмлэхүй насны сангийн бүтэц, суурь программыг шинэчлэх, баяжуулах	-	Баяжуулсан мэдээллийн сангийн тоо	0	5	1. Давхарга зүйн-707 2. Палеонтологийн-3567 3. Интрузив чулуулгийн-3362 4. Эффузив чулуулгийн-360 5. Үнэмлэхүй насны 1119 өгөгдлөөр баяжуулсан. Мэдээлэл үзэх сайт: www.mris.mn	100%	100%
Зорилт 3.2. Мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн цахим сан бүрдүүлэх, боловсруулах, баяжуулах болон хэрэглэгчийг мэдээллээр түргэн шуурхай, найдвартай хангах зорилгоор орчин үеийн, олон улсын жишигт хүрэхүйц мэдээллийн технологи, программ хангамж, найдвартай сүлжээг бий болгож тогтмол сайжруулах									
23.	3.2.1	Геологийн зургийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах, хүлээж авах	-	Үйлчилгээ үзүүлсэн эсэх: 1-Тийм 0- Үгүй	0	1	1. 1:50000-ны масштабтай Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааны картограммыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр орж хамгаалсан 8 тайлан болон 2022 онд Улсын төсвийн хөрөнгөөр	100%	100%

							хэрэгжүүлэх 5 төслийн мэдээллээр баяжуулсан. 2. Суурь мэдээллийн санд үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын судалгааг 2023, 2024 онуудад явуулах боломжтой 10 талбайг ялгаж давхцалтай ашигт малтмалын орд, илрэлийн мэдээллийг боловсруулсан. 3. Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд Эрэл үнэлгээний ажил хийх боломжтой Манган, Цагаан алт, Бал чулуу зэрэг ашигт малтмалын 10 талбайг ялган суурь мэдээллийг бэлтгэсэн. 4. 1:50000-ны масштабтай ГЗЕЭА-ын Олон гол-50, Худгийн нуруу-50, Чулуун хороот-50, Бүрхтэй уул-50 төслийн тайланг заавар журмын дагуу хүлээж авсан.		
24.	3.2.2	Гидрогеологийн судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээлэл: 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн	0	1	Гидрогеологийн Худаг-1245, Цооног-80 нэмж оруулан, нийт худгийн 2745, цооногийн 3580 өгөгдлийг бүрдүүлж баяжуулсан.	100%	100%
25.	3.2.3	Геофизикийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээллийн тоо	56	106	1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 22 тайлангийн геофизикийн ажил хийсэн талбайг зурж, нийт 106 ширхэг тайлангийн мэдээллээр санг баяжуулсан.	100%	100%
26.	3.2.4	Геохимийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээлэл: 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн	0	1	Геохимийн 500 өгөгдөл оруулж нийт 5895, Шлихийн 1700 өгөгдлөөр баяжуулсан.	100%	100%
27.	3.2.5	Өрөмдсөн цооногийн мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээллийн тоо	11207	11307	Өрөмдсөн цооногийн 300 өгөгдөл оруулж, баяжуулсан. Нийт баяжуулсан мэдээллийн тоо 11507 болсон.	100%	15%
28.	3.2.6	Газрын тосны цооногийн мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээллийн тоо	10	60	Нийт 50 цооногийн мэдээллээр баяжигдсан. Нийт баяжигдсан мэдээлэл 60 болсон.	100%	100%
29.	3.2.7	Хувийн хөрөнгийн судалгааны бүртгэлийн санг	-	Баяжуулсан мэдээллийн тоо	1030	1230	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн судалгааны бүртгэлээс 448 ширхэг мэдээллийг Геомэдээллийн системд оруулсан. Нийт 1478 өгөгдөл бүртгэгдэж, баяжигдсан.	100%	100%

		баяжуулах, боловсруулах							
30.	3.2.8	Улсын төсвийн судалгааны бүртгэлийн санг баяжуулах, боловсруулах	-	Баяжуулсан мэдээлэл	6	56	479 мэдээллийг мэдээллийн системд оруулан, нийт 485 өгөгдөл бүртгэгдэж, баяжигдсан.	100%	98.8%
31.	3.2.9	Ашигт малтмалын орд, нөөцийн улсын тоо бүртгэл хөтлөх	-	Нөөцийн бүртгэл нэмэгдсэн эсэх 0-нэмэгдсэн 1-нэмэгдээгүй	0	1	Ашигт малтмалын нөөцийн улсын тоо бүртгэлд хувийн хөрөнгөөр хайгуулыг нь гүйцэтгэсэн нөөцийн тайлангийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, нөөцийг хүлээн авсан. Үндэсний Геологийн албаны даргын тушаалыг үндэслэн, 166 тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөцийг шинээр бүртгэн, нийт 3035 нөөцийг улсын нөөцөд бүртгэсэн.	100%	100%
32.	3.2.10	Мэдээллийн системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, сүлжээний хамгаалалт, удирдлагын төхөөрөмжүүдийн болон программ хангамжийн удирдлага, ашиглалт үйлчилгээ хэвийн, бүх төрлийн тоон мэдээлэл, өгөгдлийн сангийн хадгалалт, хамгаалалт хэвийн байх ажиллагааг хангах	-	Холбогдох дүрэм журмын дагуу хэвийн ажиллагаа хангагдсан байх 0-ажиллагаа хангагдаагүй 1-ажиллагаа хангагдсан	0	1	1. Албаны сүлжээний хамгаалалтын PA-820 төхөөрөмжүүдийн PAN-OS үйлдлийн системийг 10.0.4 - 10.2.3 , GlobalProtect Client программын хувилбарыг 5.2.5 - 6.1.0 болгон хувилбарыг шинэчлэх ажлыг хийж өдөр тутмын хяналт тохируулгыг тогтмол хийсэн. 2. 24 виртуал серверийн нөөцлөлтийг өдөр тутам хийж, хэвийн тогтвортой ажиллагааг ханган ажиллаж байна. 3. Виртуал серверүүдийг нөөцлөлтийн ажиллагаанд Veeam Backup & Replication программыг ашиглаж, өгөгдлийг өөр серверт, өөр хугацааны давтамжаар нөөцлөх 2 дахь хувилбарыг нэвтрүүлж, виртуал серверүүдийн өгөгдлийг нөөцөлсөн. 4. Серверийн болон дотоод, гадаад сүлжээний ажиллагаа хэвийн тогтвортой тасалдалгүйгээр ажиллах нөхцөлийг хангаж ажилласан болно.	100%	100%
Зорилт 3.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 4 дүгээр зорилт. Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгон хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй холбох, төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох									
33.	3.3.1	Сүлжээний аюулгүй ажиллагаа, хамгаалалт, удирдлагын төхөөрөмжүүдийн болон программ хангамжийн	-	Хамгаалалтын программ хэвийн ажиллаж, жил бүрийн шаардагдах тохируулга	1	8	1. Геологи эрдэс баялгийн мэдээллийн систем, (онлайн худалдааны систем) МОНГЕОМИН, МОНГЕОЭКСП, МОНГЕОКАТ, МОНГЕОКОЛ системийн серверүүдийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажилласан.	100%	100%

		удирдлага, ашиглалт үйлчилгээ хэвийн байх нөхцөлийг хангаж ажиллах, бүх төрлийн тоон мэдээлэл, өгөгдлийн сангийн хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллагатай цахим шилжилт, хөтөлбөр төслийн асуудлаар хамтран ажиллах					2. Цахим хөгжил, Харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн төв газарт мэдээллийн системүүдийн өгөгдлийн сангийн жагсаалт судалгааг гаргаж, хүргүүлсэн. 3. DELL PowerEdge R740 - 2 серверийн шуурхай санах ойн хэмжээг 256Gb байсаныг 384 Gb болгон нэмэгдүүлсэн. 4. Виртуал орчны удирдлагын үйлдлийн систем VMware ESXi 7.0 U1-17325551 байсныг ESXi 7.0 U3-20036589 болгон шинэчилсэн. 5. Виртуал орчны сервер удирдлагын VMware vCenter Server Appliance программын хувилбарыг 7.0.0 (Build 15952599) -с 7.0.3 (Build 20150588) болгон шинэчлэх ажлыг хийсэн. 6. АМЕП төслийн санхүүжилтээр нийлүүлэгдэх EASY-UPS үл тасалдах цахилгаан тэжээлийн төхөөрөмжүүдийг хүлээн авч, серверийн өрөөнд нэмэлтээр суурилуулсан. 7. Arc4U системийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажилласан. Тооцооны хуудасны маягтын загварыг шинэчилсэн. 8. Тагнуулын Ерөнхий Газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас Үндэсний Геологийн Албаны мэдээллийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ өгөх шалгалтыг хийлгэж, дотоод сүлжээ, файл болон веб серверүүдэд, хийсвэр халдлагын шалгалтыг (Penetration testing) хийлгэсэн. 9. Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас ирүүлсэн "Үндэсний Геологийн Албанд хийсэн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тайлан"-гаар ирүүлсэн зөвлөмжийн дагуу "Эрсдэл өндөртэй" гэж дүгнэгдсэн сүлжээний switch болон бусад сервер компьютерүүдэд шаардлагатай тохируулгыг хийж, холбогдох тайланг гаргаж, хариуг хүргүүлсэн.		
Зорилт 3.4. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилт. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой, ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайн мэдээллийг нэгтгэж холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах									
34.	3.4.1	Судалгааны ажлуудын үр дүнгээр хуулиар хориглосон, хязгаарласан	-	Ялгасан талбайн тоо	0	100	Үндэсний Геологийн Албаны даргын 2022.03.07-ны өдрийн А-09 дүгээр тушаалаар байгуулагдсан "Сонгон шалгаруулалтаар явуулах талбайн геологийн суурь судалгааны ажлын ерөнхий	100%	100%

		талбайтай давхцалгүй ашигт малтмалын хуримтлал бүхий талбайг техник, технологийн аргачлалтай хослуулан ялгах					мэдээллийг бэлтгэх” ажлын хэсгийн хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн хэрэгцээ шаардлага хангах байдлаар нь 5 ангилж, нийт 415 ширхэг талбайн мэдээллийг техник, технологийн аргачлалтай хослуулан, ялгаж бэлтгэн, УУХҮЯ-ны Геологийн бодлогын газарт тус Албаны нууц хамгаалах ажилтнаар дамжуулан, албан бичгээр хүргүүлсэн.		
ЗОРИЛГО 4. Төрийн захиргааны төв байгууллагад геологийн судалгааны бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох төрийн захиргааны болон судалгааны байгууллагатай гидрогеологи, геофизик, геоэкологи, мөн түүнчлэн ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны эрлийн, гэрээлэгчийн хайгуул, ашиглалтын талбайд хамаарах мэдээллээр улсын геологийн фонд, баримтын төвийг арвижуулан, харилцан үйлчилгээ үзүүлэх									
Зорилт 4.1. Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах шат дараалсан арга хэмжээ авах									
35.	4.1.1	Геологийн архивын хадгаламжийн санг камержуулах, хяналтын систем нэвтрүүлэх, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах	-	Хадгаламжийн сангийн хяналт сайжирсан эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	Геологийн баримтын төв архивын Үйлчилгээний өрөө, Тайлан хүлээн авах өрөө, нөхөн бүрдүүлэлтийн хөмрөгийн өрөөнүүдэд тус тус хяналтын камер байршуулж, архивын аюулгүй байдлыг бүрэн хангасан.	100%	70%
36.	4.1.2	Агаарын зургийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах	-	Хадгалалтын нөхцөл сайжирсан эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	Агаар, сансрын зургуудын хавтас урагдаж гэмтсэн, задгай байдлаар хадгалагдаж байгаа нийт зургуудын жагсаалт, танилцуулга бэлтгэсэн. “Өрнөх Бэйлийнхэн” ХХК-аас баримт цэгцлүүлэх гэрээ байгуулж, үнийн санал, танилцуулга авсан. Хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, сэргээн засварлахад бэлэн болсон.	50%	50%
Зорилт 4.2. Газрын хэвлийд хийгдсэн бүх төрлийн судалгааны ажлын тайлан мэдээг нэгтгэн хүлээн авах, тайлан мэдээг тогтмол гаргах									
37.	4.2.1	Геологи, уул уурхайн судалгааны бүх үе шатны баримтыг хүлээн авах, сан хөмрөгөө баяжуулах, төвлөрүүлэн хадгалах	-	Сан хөмрөгийн тоо 0-нэмэгдээгүй 1-нэмэгдсэн	0	1	1. Геологийн баримтын төв архивын сан хөмрөгөө Монголын ард түмний амьдрал, хөгжлийн түүхийг тусгасан эрдэм шинжилгээ, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой баримтаар нөхөн баяжуулах зорилгоор 434 тайлангийн 2950 хадгаламжийн нэгж хүлээн авсан. Үүнд: -Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан – 146 -1:50000 масштабтай зураглалын ажлын үр дүнгийн тайлан - 12, -Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл – 276. -Цахим баримт- 343 /CD, DVD/. 2. Геологийн баримтын төв архив нь 2022 онд нийт 434 тайлангийн 2950 хадгаламжийн нэгжийн нэг бүрчилсэн бүртгэлийг архивын данс	100%	100%

						бүртгэл, эрэлт хайлтын Arc4U программд шивж оруулж иргэн, хуулийн этгээдэд архивын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлсэн. 3. Цахим сан бүрдүүлэх зорилгоор 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хүлээн авсан тайлангийн 596 тушаал, дүгнэлтээр PDF файл үүсгэж архивын данс бүртгэл, эрэл хайлтын Arc4U программд оруулсан. Шинээр 73 үйлчлүүлэгчийн цахим бүртгэл үүсгэсэн. 4. Архивын эрэлт хайлтын Arc4U программын талбай ордын бүртгэл хэсэгт 354 тайлангийн товч мэдээлэл, ордын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, ашигт малтмалын төрөл, тушаал, дүгнэлтийн дугаар, огноог шивж оруулсан. 5. Архивд шинээр хүлээж авсан 227 тайлангийн 1580 хадгаламжийн нэгжийн нэг бүрчилсэн бүртгэлийг архивын данс бүртгэл, эрэлт хайлтын Arc4U программд шивж оруулсан. 6. Хадгаламжийн нэгжид тоо бүртгэл, техник боловсруулалт хийсэн. 7. Үүнд: -417 ном, 364 дэвтэр, 312 хавтсанд тоо, бүртгэл үйлдсэн. -9801 хавсралт зураг дугаарласан -171 номын уут наасан, -30297 хуудас гараар дугаарласан, -5010 ш агаарын гэрэл зургийг бүртгэсэн, -989 ш бар код наасан, -360 хадгаламжийн нэгжийн хавтаст дугаарлалт бичсэн. -47 баримтын хавтас завсарласан. -68 баримтын нуруу дугаарласан. 8. Архивын баримтыг устаж, үрэгдэх аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор урагдаж гэмтсэн баримтыг сэлбэн засаж, сэргээн шинэчилж, баримтыг насжилтыг уртасгасан. Үүнд: 312 ХН-д шинэ хавтас хийсэн, 198 ширхэг хавсралт зургийг сэлбэн зассан. 9. Цорын ганц хувь, эх баримтыг ашиглалтаас чөлөөлж, баримтыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 76 хадгаламжийн нэгжид ашиглалтын хувь үүсгэсэн.		
--	--	--	--	--	--	---	--	--

							10.Улсын үзлэгийн дүгнэлтийн мөрөөр архивын баримтын данс бүртгэл үйлдсэн. Үүнд: -Газрын тосны жилийн ажлын хайгуулын болон гүйцэтгэлийн 415 тайлангийн 704 хадгаламжийн нэгж. -Нөхөн бүрдүүлэлтийн хөмрөгийн 1495 тайлангийн 3938 хадгаламжийн нэгж. 11.Төрийн архивын улсын үзлэгийн дүгнэлтийн дагуу Архивын ерөнхий газрын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын архивын баримтын нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Пүрэвсүрэн болон Үндэсний төв архивын Зааварлагч, арга зүйч Ж.Рэнцэнмядаг нараас архивын баримтыг хөмрөгийн ангиллаар ангилах, данс бүртгэл үйлдэх талаар заавар, зөвлөгөө авч, ажилдаа хэрэгжүүлэн ажиллав.		
38.	4.2.2	Монгол улсын чулуун дээжийг хүлээн авч, цахим санг бүрдүүлэх, тулгуур зүсэлт гаргах боломжийг бүрдүүлэх	-	Чулуун дээжийн сан баяжсан эсэх 0-баяжуулаагүй 1-баяжуулсан	0	1	Чулуун дээж хүлээн авч, сан хөмрөгөө баяжуулсан. Үүнд: - Чулуун дээж 429ш, - Керний дээж 132ш, - Аншлиф 93ш, - Тунгалаг шлиф 1264ш тус тус хүлээн авч, хадгаламжийн нэгжийн нэг бүрчилсэн бүртгэлийг архивын данс бүртгэл, эрэлт хайлтын Arc4U программд шивж оруулсан.	100%	100%
39.	4.2.3	Төрийн архив, гео-мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, Улсын төсөвт орлого төвлөрүүлэх	-	Орлогын хэмжээ /сая төгрөг/	0	120	1. Уншлагын танхимаар тайлант хугацаанд нийт 1336 хүнд 2479 тайлангийн 7930 хадгаламжийн нэгжээр үйлчилгээ үзүүлж, архивын баримтаас А4-39578 хуудас, А3-14990 хуудас хуулбарлан, 2784 хавсралт зураг сканер хийж, улсын төсөвт 117.22 сая.төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан. Үүнд: - тайлан уншлага-20.04 сая.төгрөг, - канон-51.67 сая.төгрөг, - сканер-40.91 сая.төгрөг - илүү төлөлт-1,8 сая.төгрөг, - агаарын гэрэл зургийн түрээс-0,8 сая.төгрөг. 2. Төрийн байгууллага, дотоод хэлтэс, нэгж, хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд нийт: - 530 хүнд (давхардсан тоогоор) 2788 тайлангийн 4421 хадгаламжийн нэгжээр үйлчилгээ үзүүлсэн.	100%	97.7%

								- Архивын баримтаас А4-12489 хуудас, АЗ-256 хуудас хуулбарлан олгосон. - 2297 хавсралт зураг сканердаж олгосон. - 20 хүнд 26 тайлангийн 1861 хуудас материалд архивын хуулбар үнэн тэмдэг дарж, олгосон. - Australia Mongolia Extractives Program хамтарсан төсөлд 399 тайлан үзүүлсэн. - Геологийн баримт 1 төсөлд 180 тайлан үзүүлсэн. 1. Нийт 176 албан бичгээр ирсэн хүсэлтэд хариу өгч шийдвэрлэсэн. Үүнд: Уншлагын танхимаар тайлантай танилцуулж хэрэгтэй мэдээллийг нь хуулбарлан өгч, улсын төсөвт орлого төвлөрүүлсэн. - 26 албан тоотуудын хариу, лавлагаа хүргүүлсэн. Албан бичгээ ирүүлсэн байгууллагын төлөөлөгчтэй биечлэн уулзах болон утсаар холбогдон, хэрэгтэй мэдээлэл лавлагааг өгсөн. - Геологийн судалгааны төвийн 5 албан хүсэлтийн дагуу тус байгууллагын болон геологичдынх нь бүтээлийн жагсаалтын лавлагааг гаргаж өгсөн. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 3 албан хүсэлтийн дагуу тус сургуулийн оюутнуудад тайланг уншлагын танхимаар хөнгөлөлттэй үнээр уншуулж үйлчилсэн. 2. Тайлант хугацаанд 342 удаа зохиогч, байрлал, судалгааны нэр, гүйцэтгэгч байгууллагын нэр, огноо зэргээр тайлангийн нэр, дугаарын лавлагаа гаргаж өгсөн. 3. Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан 81 тусгай зөвшөөрлийн талбайн зардлын нөхөн төлбөр тооцох, гэрээ хийх хяналтын хуудас дээр тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах гүйцэтгэсэн ажлын 2528 тайлангаас шүүлт хийж, жагсаалт гаргасан. 4. Нийт 3531 тайлангаас шүүлт хийж, 327 хүнд 561 хуудас лавлагаа олгож, хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үйлчилсэн.	
ЗОРИЛГО 5. Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, салбарыг сурталчлах, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд, олон улсын геологийн алба, байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх									

Зорилт 5.1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах									
40.	5.1.1	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, шийдвэрлүүлэх, хариуг хүргүүлэх арга хэмжээ авах, холбогдох журмын дагуу хэрэгжилтийн байдлыг нэгтгэн холбогдох газарт хүргүүлэх	-	Шийдвэрлэлтийн хувь	98	99	Үндэсний геологийн албанд 2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд 60 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн. Нийт шийдвэрлэгдсэн өргөдөл 58, хяналтад 2 өргөдөл байна. 11-11 өргөдөл гомдлын сайтад Төслийн санхүүжилт олгохгүй байгаа тухай 2 гомдол ирснийг шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал: Үүнд: Албан бичгээр 52, биечлэн уулзаж шийдвэрлэсэн 5, утсаар 3 өргөдлийн хариу өгч, шийдвэрлэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэх тендертэй холбоотой "Голденхилл" ХХК-ийн гомдолд хариу тайлбар гаргаж өгсөн. /Тендерийн ажлын хэсгээс/. Өргөдөл, хүсэлтүүд цаг хугацаандаа 100% шийдвэрлэгдсэн байна. -Шүүхийн шатанд явж байгаа нэхэмжлэл шүүхээс гарч буй шийдвэрүүд шүүхээс тогтоосон цаг хугацаанд шийдвэрлэгдсэн байна. УУХҮЯ-нд өнгөрсөн оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2022 оны 1/04, 2022 оны I улирлын шийдвэрлэлтийн мэдээг 1/193, II улирлын мэдээг 2022.06.21-ний 1/357, III улирлын мэдээг 2022.10.05-ны 1/545 дугаар албан бичгээр, IV улирлын мэдээг цаг хугацаанд нь тус тус хүргүүлсэн. Ийнхүү 2022 оны улирал бүрийн мэдээг цаг хугацаанд нь хүргүүлж, тайлагнаж ажилласан.	100	90%
41	5.1.2	Төрийн албаны зөвлөлд шаардлагатай тайлан мэдээ, мэдээлэл, шилжилт хөдөлгөөний талаарх тайланг бэлтгэн хүргүүлэх	-	Мэдээ тайлан хүргүүлсэн эсэх: 0- хүргүүлээгүй 1 - хүргүүлсэн	0	1	1. Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн программд албан хаагчдын мэдээлэлд шаардлагатай өөрчлөлт хөдөлгөөнийг бүртгэсэн. Үүнд: ажилд орсон 9, шилжин сэлгэж томилогдсон 2 албан хаагч, ажлаас түр чөлөөлөгдсөн буюу хүүхэд асрах, сургалтын урт хугацааны чөлөөтэй 3 албан хаагч, нийт 14 хүн хамаарна. 2. Геологийн баримтын төв архивын Архивын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн бөгөөд улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан. 3. Төрийн албаны хүний нөөцийн программ шинэчлэгдсэнтэй холбоотой нийт албан	100%	90%

							хаагчдын хувийн мэдээллийг шинэчлэн, ажилласан жилийг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн бүртгэлтэй нэг бүрчлэн тулгаж үнэн зөв бүртгэл хийж цалингийн програмтай холбогдох нөхцөлийг бүрэн хангасан. 4. УУХҮСайдын 2022.04.15-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар олгосон Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг батлагдсан төсөвт багтаан зохих түвшин нэмэх судалгааг гарган, удирдлагад танилцуулж, агентлагийн даргын 2022.04.18-ны өдрийн А-11 дүгээр тушаалаар Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснийг 2022.10.06-ны өдрийн А-25 дугаар тушаалаар өөрчлөлт оруулсан. 5. Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин өөрчлөгдсөнтэй холбоотой мэдээллийг Хүний нөөцийн системд тухай бүрд нь засварлан шинэчилсэн. 6. Байгууллагын орон тооны мэдээллийг шилэн дансанд 01-12 сар тус бүрд шинэчлэн оруулсан. Төрийн албаны зөвлөлийн 2022.10.24-ний 06/2070 дугаар албан бичгийн дагуу төрийн албаны чадавхыг бэхжүүлэх талаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг гарган 2022.11.16-ны 3/0627 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
42.	5.1.3	Үндэсний геологийн албаны 17 нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогыг мэдүүлгийг https://meduuleg.iaac.mn цахим хуудсаар шинэчлэн бүртгүүлж баталгаажуулах; холбогдох тайланг боловсруулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байх,	-	Зохион байгуулсан эсэх 0-Үгүй 1-Тийм	0	1	1. Үндэсний геологийн албаны нийт 18 төрийн захиргааны албан хаагч байхаас 2 сул ажлын байртай тул 16 албан хаагчийн ХАСХОМ-ыг шаардлагатай засвар, өөрчлөлтийг хийлгүүлэн, хуулийн хугацаанд баталгаажуулах ажлыг гүйцэтгэсэн. 2. Тайлант хугацаанд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт гараагүй. Шинээр томилогдох болон ажил хавсран гүйцэтгэхтэй холбоотой 4 албан хаагчийн ХАСУМ эрх нээж, холбогдох бүртгэлийг хөтөлсөн. 3. Үндэсний геологийн албаны 2021 оны Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, 2022.01.11-ний өдрийн 1/13 дугаар албан бичгээр Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн.	100%	90%

		“Авлигын эсрэг төлөвлөгөө” боловсруулсан байх					Үндэсний геологийн албаны албан хаагчдын 2021 оны ХАСХОМ-той холбоотой тайлан мэдээг 2021.02.28-ны өдрийн 1/78 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүнд: - Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн 2021 оны тайлан; - Албан тушаалтны 2021 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэл; - Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл; - Албан тушаалтнуудын 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн хураангуй мэдээлэл; - Албан хаагчдын 2021 оны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн бүртгэл.		
43.	5.1.4	Байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах. ОХУ, БНХАУ-тай харилцаа, холбоо тогтоох	-	Зохион байгуулсан эсэх 0-байгуулсан; 1-байгуулаа-гүй	0	1	Үндэсний геологийн алба гадаад харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй зохион байгуулан, харилцаа холбоо тогтоон ажиллав. Үүнд: <u>Оросын холбооны улстай:</u> Үндэсний геологийн албаны байранд Албаны дарга О.Чулуунтай ОХУ-ын Зарубежгеологи ХК-ийн Ерөнхий захирал Десяткин Алексей 2022.03.18-ны өдөр хүрэлцэн ирж, хоёр талын ажлын уулзалт болов. Хамтын ажиллагааг 2022 онд үргэлжлүүлэх, орон нутгийн тодорхой газруудад ажиллах, Зарубежгеологи ХК-ийн удирдлагууд Монгол Улсад дахин албан ёсоор ажиллахаар тохиролцов. Уулзалтын хурлын тэмдэглэлийг УУХҮСайд Г.Ёндонд албан бичгээр хавсаргаж, хүргүүлэв. <u>Бүгд Найрамдах Хятад Ард Улстай:</u> Таван улсын хамтарсан “Хойд, төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийг дайруулан геофизикийн гүний профиль татах чиглэл, санхүүжилтийн асуудлыг хамтрагч талуудтай харилцан шийдвэрлэх ажлын хүрээнд БНХАУ-ын талаас санхүүжилтийг гаргуулахаар ярилцаж байна. Санхүүжилтийг баталгаажуулах ажлыг холбогдох дээд байгууллагын удирдлагуудад танилцуулан зөвшилцөх, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвшөөрөл авах	100%	100%

						зэрэг ажлууд төслийн геологийн даалгаварт тусгагдсан. <u>Бүгд Найрамдах Польш Улстай:</u> БНПУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Крзиштоф Бойко болон Польшийн геологийн институтийн төлөөлөгч нар дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд: Польшийн геологийн институт "Монгол Польшийн хамтарсан Хасагтын талбайн геологийн судалгаа, эрлийн ажил"-ын тайлан холбогдох зургууд болон электрон файлын хамт хүлээлгэж өгснийг Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архив хариуцсан хэлсийн дарга М.Баясгалан болон мэргэжилтний хамт тайланг хүлээж авч, холбогдох акт үйлдэв. Польшийн геологийн институт, Үндэсний геологийн алба хоорондын байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хамтарч ажиллах боломжит судалгааны төслийн талаар тус тус хэлэлцэв. <u>Бүгд Найрамдах Солонгос Улстай:</u> КИГАМ-ҮГА нар Үндэсний геологийн албаны байранд уулзалт зохион байгуулан дараах асуудлаар ярилцаж, ажил хэрэг болгохоор шийдвэрлэв. Үүнд: БНСУ-д 2024 онд зохион байгуулагдах гэж буй 37 дугаар Олон улсын Геологийн конгрессийн хээрийн сургалт ажлыг Монгол Улсад зохион байгуулах боломжийн талаар ярилцав. Төмөр замын трассын ирээдүйн стратегийг төлөвлөх ажлын хүрээнд тодорхой бүс нутгийн ашигт малтмалын нөөц, хэтийн төлөвийг судлах төслийг Геологийн судалгааны төв ТӨҮГ, КИГАМ хамтран хэрэгжүүлж ҮГА хяналт тавин ажиллаж байна. Тус төсөлтэй холбоотойгоор Геологийн судалгааны төв ТӨҮГ, КИГАМ, ҮГА-ны холбогдох мэргэжилтнүүд шаардлагатай уулзалтуудыг зохион байгуулан ажиллаж байгаа. 12 дугаар сард зохион байгуулагдсан БНПУ болон Монгол Улс хоорондын ашигт малтмалын нөөц ба зам тээврийн салбарын хамтын ажиллагаа сэдэвт хамтарсан хуралд ҮГА-наас зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн ажиллав.		
--	--	--	--	--	--	--	--	--

							-Үндэсний геологийн алба, БНПУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт 2022.09.28-ны өдөр гарын үсэг зурж, албажуулсан. <u>CCOP (Coordinating Committee for Geoscience Programmes in East and Southeast Asia)-тэй:</u> Зүүн, зүүн өмнөд Азийн геологийн шинжлэх ухааны зохицуулах хороонд ҮГА-ны дарга О.Чулуун Монгол Улсын төлөөлөгчөөр нэгдэв. Монгол Улсад зохион байгуулагдсан CCOP-н удирдах зөвлөлийн 78 дугаар хурлын бэлтгэл ажилд албанаас баг гаран ажиллаж, амжилттай зохион байгуулав.		
44.	5.1.5	Жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах, жендерийн судалгаа гаргах, сургалт зохион байгуулсан байх	-	Сургалт зохион байгуулсан эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	1. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Хүйсийн 60:40 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах" тухай заалтыг манай байгууллага нь эрэгтэй албан хаагч 11, эмэгтэй албан хаагч 21 буюу 66:34 гэсэн хүйсийн харьцаатай ажиллаж байгаа нь Жендерийн тухай хуулийг хэрэгжилтийг хангаж байгаа юм. 2. Мерит төслөөс зохион байгуулдаг "Эмэгтэйчүүдийн манлайлал" цуврал уулзалтуудад байгууллагын төлөөллүүдийг оролцуулж хэвшсэнээр жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллаж байгаа болно. 3. Жендэрийн үндэсний хорооноос 2022.12.01-ний өдөр зохион байгуулсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын хамтын ажиллагаа" зөвлөлдөх семинарт 1 ажилтан хамрагдсан. 4. Мерит төслөөс 2022.12.07, 08-ны өдрүүдэд зохион байгуулсан "Жендэрийн клуб" тавдугаар чуулга уулзалтад 1 ажилтан оролцож, сурсан мэдсэнээ хамт олонтойгоо хувалцаж, танилцуулсан. 5. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д манай байгууллага нэгдэж 2022.12.07-ны өдөр мэдээллийг https://ngs.gov.mn сайтад байршуулсан.	100%	50%
45.	5.1.6	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг	-	Албан хэрэг хөтлөлтийн	Бичиг хэргийн	92%	2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын хэмжээнд:	100%	90%

		тогтмол, шуурхай эрхлэн явуулах, ажилтан, албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын талаар аргазүйн зөвлөгөө өгч ажиллах		үндсэн заавар, холбогдох журмын хэрэгжилтийг хангасан эсэх	шийдвэрлэлт 91%		-Ирсэн бичиг 1191, -Явуулсан бичиг 720, -Өргөдөл гомдол 60 ирсэн байна. Байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн байдал 96 хувьтай байгаа ба хяналтад 29 албан бичиг байна. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны 56 төслийн сарын гүйцэтгэлийг сар бүрийн 20-30-ны өдрүүдэд project@ngs.gov.mn хаягаар хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлэн, буцаах болон шаардлага хангасан байгууллагуудад мэйл явуулах, бичгээр хүлээн авах албан бичгийн стандартыг мөрдүүлэн ажиллах арга хэмжээ авч ажилласан. Тайлант хугацаанд Үндэсний геологийн албаны даргын: Боловсон хүчний 62, үйл ажиллагааны 40, нөөц бүртгэх тушаал 101 батлагдан гарсан болно. Өнгөрсөн оны Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засгийн газрын 246 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг ажилдаа мөрдөн, албан хаагчдын өдөр тутмын албан хэрэг хөтлөлтөд заавар зөвлөгөө өгч ажиллав.		
Зорилт 5.2. Салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах									
46.	5.2.1	Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулах, ажилтан, албан хаагчдыг богино, дунд хугацаат сургалтад жигд хамруулах ажлыг зохион байгуулах.	-	Зохион байгуулсан эсэх: 0-Үгүй; 1-Тийм	0	1	Сургалтын төлөвлөгөөнд Хувь хүний хөгжил, манлайлал, мэргэжлийн, Удирдлагын академийн мэргэшүүлэх зэрэг чиглэлээр 9 сургалтыг тусгаж, бүтэн жилийн байдлаар архив, хүний нөөц, мэргэжил дээшлүүлэх, Шинэ сэргэлтийн бодлого, 2050, эрүүл мэнд, ТАЗ-ийн, Авлигын эсрэг, мэдээллийн аюулгүй байдлыг хангах гэх мэт 9 төрлийн сургалтад давхардсан тоогоор 165 албан хаагч хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлсэн. Үүнд: Танхимаар: - 06 дугаар сард Архивын ерөнхий газрын төлөвлөгөөт мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч хамрагдсан. - 06 дугаар сарын 15-17-нд Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад 1 албан хаагч хамрагдана.	100%	100%

							- 08 дугаар сарын 30-нд "Нийслэлийн иргэдийн хэрэглээний боловсролын төв"-ийн сургалтад 21 албан хаагч хамрагдсан. - 09 дүгээр сарын 15, 16, 30-нд Мерит төслийн ёс зүйн сургалтад давхардсан тоогоор нийт 65 албан хаагч оролцов. Цахимаар: - 06 дугаар сарын 3-4-нд ТАЗ-өөс зохион байгуулсан "Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалтад ТЗУХ-ийн 2 албан хаагч хамрагдав. - 06 дугаар сард ТАЗ-ийн Төрийн байгууллагын бүтээмж, Төрийн албаны шинэтгэлийн эхлэл, Бүтээлчээр хурдан уншихуй, Монгол орны хөгжлийн хэтийн төлөв сэдэвт сургалтуудад нийт 5 албан хаагч хамрагдав. - 07 дугаар сард АТГ-ын Авлигын эсрэг давтан цахим сургалтад 5 албан хаагч хамрагдав. - 10 дугаар сарын 13-нд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн удирдлага системт шинжлэх ухаан болох нь" сэдэвт сургалтад нийт 6 албан хаагч хамрагдав. - 10 дугаар сарын 27-нд ТАЗ-өөс зохион байгуулсан "МУ-ын үндэсний болон гадаад аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлууд" сэдэвт сургалтад нийт 10 албан хаагч хамрагдав. - 11 дүгээр сарын 10-нд ТАЗ-өөс зохион байгуулсан "Монголын тусгаар тогтнолын үнэ цэнэ" сэдэвт сургалтад нийт 8 албан хаагч хамрагдав. - 11 дүгээр сарын 17-нд ТАЗ-өөс зохион байгуулсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3 хэрэгжилтийн явц" сэдэвт сургалтад нийт 7 албан хаагч хамрагдав. Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтийн 2022 оны 09 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсан "Шинэ сэргэлтийн бодлого" сэдэвт сургалтад 8 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтийн 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан сургалт:		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5 албан хаагч, Систем сэтгэлгээ сэдэвт сургалтад 2 албан хаагч, Зан үйлийн нөлөөлөл сэдэвт сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн дунд хугацааны - Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч суралцаж байна. - Ахлах түшмэлийн багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж төгссөн, одоо 1 албан хаагч хамрагдаж байна. - Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт – 1 албан хаагч хичээл нөхөлтөд хамрагдаж төгссөн. - Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт – 1 албан хаагч суралцаж төгссөн, одоо 2 албан хаагч суралцаж байна.		
Зорилт 5.3. Үндэсний геологийн албаны Стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилго; Зорилт 2. Салбарын хууль, эрх зүйн орчны харилцааг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх									
47.	5.3.1	Ашигт малтмалын тухай хууль; Газрын хэвлийн тухай хууль; Нөөцийн баланс гаргах журамд санал өгөх /1.2.1/	-	Боловсруулж, хүргүүлсэн эсэх: 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	УУХҮЯ-наас 2022.01.03-ны өдөр албаны и-мейлээр ирүүлсэн Ашигт малтмалын тухай хуулийн төслийн хувилбарт ажлын хэсгийн хуралдаануудад хэлэлцэж, эцэслэж байснаас зарчмын ялгаатай саналуудыг оруулсан байсан. Түүнчлэн хуулийн үзэл баримтлалын төсөлд геологийн судалгааны талаар тус албанаас санал оруулахаар хүргүүлсэн боловч төсөлд өөрчлөлт ороогүй байсан. Ийнхүү Ашигт малтмалын тухай хуулийн төсөлд зарчмын өөрчлөлтүүдийг оруулсан үндэслэл, тайлбарын талаар тодруулга авах, цаашид төслийг ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн, аливаа өөрчлөлтийг оруулж байх саналаа боловсруулж, 2022.01.26-ны өдрийн 1/39 дүгээр албан бичгээр УУХҮСайдад хүргүүлсэн. Уг асуудлаар УУХҮСайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаан 2022 оны 2 дугаар сард болж, Үндэсний геологийн албанаас хөндөж тавьсан асуудлууд, хуулийн зүйл заалтуудыг төсөлд дахин оруулсан болно. Ашигт малтмалын тухай хуулийн үзэл баримтлалыг эрдэмтэд, судлаачдаар хэлэлцүүлэх	100%	50%

							ажлыг 2022.12.08-ны өдөр УУХҮЯ-нд хэлэлцүүлсэн.		
48.	5.3.2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлд санал өгөх	-	Боловсруулж, хүргүүлсэн эсэх: 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	УУХҮСайдын 2022.01.06-ны өдрийн 01/32 дугаар албан бичгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөлд санал оруулах чиглэл ирүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгэж буй геологи судалгааны ажлуудын чанар, гүйцэтгэлийн хувьд ихээхэн дутагдалтай байдлыг үүсгэж байгаа бөгөөд энэ нь дараах шалтгаантай. Үүнд: 1. Геологи судалгааны ажлууд нь шинжлэх ухааны ач холбогдол өндөр, геологийн суурь судалгааны чиглэлээр хэрэгжих шаардлагатай байдаг. Уг ажлуудыг тогтсон даалгаврын дагуу, шинжлэх ухааны хувьд тогтсон арга аргачлалаар хийгддэг ажил үйлчилгээтэй хольж болохгүй. 2. Геологи судалгааны ажлыг гүйцэтгэх тодорхой төслийн гүйцэтгэгч нь захиалагчид төслөө хамгаалж, мэргэжлийн чадвартай гэдгээ өөрийн өмнө нь хийсэн бүх зүйлийнхээ үр дүнг хэлэлцүүлэх байдлаар эрдэмтдийн зөвлөлтэй зөвшилцөн, мэтгэлцээний зарчмаар сонгогдож, үйлчилгээ үзүүлэх эрхээ хамгаалдаг. Энэ нь хуулийн төслийн ерөнхий зарчим, мөн төслийн 25.6-д заасантай зөрчилдөж байна. /шууд болон шууд бусаар холбоо тогтоохгүй/. 3. Захиалагч байгууллага нь мэргэжлийн байгууллага байх тул өөрсдөө төслөө хянах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг танах эсвэл нэмэгдүүлэх боломжтой байхыг шаарддаг. Энэ нь тухайн газар нутагт ашигт малтмал байх эсэх нь тодорхой бус байдагтай холбоотой. 4. Ийнхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэгт Хуулиар төрийн нууцад хамааруулсан тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, галт зэвсэг, ажил, үйлчилгээ болон батлан хамгаалах материаллаг нөөцөд шаардлагатай барааг худалдан авах, шинжлэх ухааны ач	100%	90%

							холбогдол бүхий энэ хуулийн 3.1.1-д зааснаас бусад геологи /газрын хэвлий/-ийн суурь болон нарийвчилсан судалгаатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэх заалтыг нэмж тусгуулахаар УУХҮЯ-ны Геологийн бодлогын газарт санал, тайлбарын хамт хүргүүлсэн.		
49.	5.3.3	Шинээр гарах, хууль дүрэм журмууд боловсруулах, санал өгөх, УУХҮЯ-нд хүргүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулах	-	Боловсруулж, хүргүүлсэн эсэх: 0-хүргүүлээгүй 1-хүргүүлсэн	0	1	1. “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын төслийг боловсруулж, УУХҮЯ-нд хүргүүлсэн. Уг журам УУХҮСайдаар 2022.05.02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлагдаж, нийтээр дагаж мөрдөгдөх Захиргааны хэм хэмжээний актын бүртгэлийн санд 5828 дугаарт бүртгэгдсэн болно. 2. УУХҮСайдын 2022.01.14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын төсвийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Үндэсний геологийн албанд шилжүүлсэнтэй холбогдуулан, Албаны 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан саналаа УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалд 2022.01.25-ны өдрийн 1/35 дугаар албан бичгээр боловсруулж, хүргүүлсэн. 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УУХҮЯ-ны Геологийн бодлогын газарт саналаа боловсруулж, танилцуулгын хамт албан захидлаар хүргүүлсэн. 4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төсөлд санал өгөх ажлын хүрээнд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2022.05.23-ны өдрийн ХЭГ/1169 тоот албан бичгээр ирүүлсэн тогтоолын төсөлтэй танилцан, саналаа боловсруулж, УУХҮСайдад 2022.05.26-ны өдрийн 1/280 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 5. Усны тухай хуулиар Усны газар, Үндэсний геологийн албаны чиг үүргийг давхардуулан хуульчилсантай холбогдуулан усны судалгаатай холбогдох ажлыг төрийн зүгээс зохион байгуулах, хэрэгжилтийг хангах асуудлаар Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Усны газартай ажил	100%	100%

							төрлийн уулзалт зохион байгуулж ажиллав. 2022 оны хагас жилийн байдлаар Усны газартай хэд хэдэн уулзалтын үр дүнд хуулийн хэрэгжилттэй холбогдох хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх тухай саналаа тус тусын харьяа яамдаар дамжуулан тавьж шийдвэрлүүлэх талаар харилцан тохиролцсон бичиг баримтыг ойрын хугацаанд гаргахаар ажиллаж байна.		
50.	5.3.4	Геологийн судалгааны ажлуудын явц үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэх	-	Мэдээлэл хүргүүлсэн эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	2022.02.25-ны өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн холбогдох бүрэлдэхүүн албаны Геологи, эрдэс баялаг, мэдээллийн сангийн ерөнхий, үндсэн болон нарийвчилсан төслийн мэдээллийн сангийн бүтэц, зохион байгуулалтын асуудлаар танилцсан. Энэ үеэр танилцуулсан танилцуулга болон холбогдох мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга С.Ширбазарт 2022.03.03-ны өдрийн 1/91 дүгээр албан бичгийг хавсралтын хамт хүргүүлсэн. Үндэсний геологийн албаны холбогдох асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй тогтмол холбоотой ажиллав.	100%	70%
51.	5.3.5	Судлаачийн журам боловсруулах, батлуулах	-	Батлуулсан эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	Байгууллагад туслах үйл ажиллагааг цогцоор хөгжүүлэх, оюутнуудад мэдлэг чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, судлаачид болон оюутныг ном товхимол, уншлагын танхимаар хангах зорилгоор танхим гаргаж, түүнд мөрдөж ажиллах “Судлаачийн журам” боловсруулж ажиллав. Уг журмын хүрээнд хөрөнгө санхүүжилтийн асуудал нь Төсвийн хэмнэлтийн тухай хуультай уялдахгүй байгаа тул журмыг хэлэлцээгүй батлаагүй байгаа болно. /Үндэсний геологийн албанаас шалтгаалахгүй зогсонги байдалд байна. хуулийн 12.2.3/.	70%	50%
Зорилт 5.4. Төсөв хуваарилах, зарцуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/06 дугаар тушаал. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих									
52.	5.4.1	Эрх шилжиж ирсэнтэй холбогдуулан барьцаа хөрөнгө, аргачлал хяналтын зардлын данс нээлгэх, сар бүрийн	-	Албан бичиг хүргэгдсэн эсэх 0-үгүй 1-тийм	0	1	УУХҮСайд 2022.01.14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн санд /Геологийн байгууллагын санхүүжилт-100900018006/, 100900018019	100%	70%

		санхүүжилтийн хуваарь батлуулах, байгууллагын худалдан авах ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулах зэрэг ажлаар УУХҮЯ, СЯ-нд албан бичиг хүргүүлэх					/Үндэсний геологийн алба ХО ТХяналт-100900018371/, /Үндэсний геологийн алба барьцаа-100900018352/, /10090001853- Үндэсний геологийн алба ТЗ барьцаа/ тоот дансуудыг шинээр нээлгэж төсөл хэрэгжүүлэгч 54 аж ахуйн нэгжийн 2022 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологийн хайгуулын санхүүжилтыг гүйцэтгэлээр сар бүр санхүүжүүлэн ажилласан.		
53.	5.4.2	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмыг шинэчлэн санал өгөх, аргачлал хяналтын зардлын зарцуулалтад санал өгөх	-	Баталсан эсэх: 0-батлаагүй 1-баталсан	0	1	УУХҮСайдын 2022.01.14-ний өдрийн А/06 дугаар тушаалаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажилд зарцуулах төсвийн эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан 2022.05.02-ны өдрийн УУХҮСайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/87 дугаар тушаалыг баталгаажуулсны дагуу дагаж мөрдөж ажиллаж байна.	100%	90%
54.	5.4.3	Батлагдсан санхүүжилтийн хуваарийн дагуу сар бүр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны ажлын төсвийн гүйцэтгэлийг хүлээн авч санхүүжүүлэх	-	Гүйцэтгэлийг санхүүжүүлсэн эсэх: 0-үгүй 1-тийм	0	1	1. Геологи судалгааны 56 төслийн гүйцэтгэлийг хянаж, 2022.05.02-ны өдрийн УУХҮСайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/87 дугаар тушаалын дагуу 2022 оны 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12 дугаар сарын гүйцэтгэлээр нийт 56 төслийн санхүүжилтын тайланг гүйцэтгэлээр хүлээн авч, Сангийн яаманд цаг хугацаанд нь хүргүүлэн ажиллаж 27,7 тэрбум төгрөгийн санхүүжилтыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд олгосон. 2. Улсын төсвөөр хийгдэх геологи судалгааны ажлын 2022 оны 1-12 дугаар сарын гүйцэтгэлийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч, хянан, баталгаажуулж, удирдлагад танилцуулан, Сангийн яам болон УУХҮЯ-нд цаг тухай бүрд нь хүргүүлсэн.	100%	90%
55.	5.4.4	Батлагдсан төлөвлөгөөний дагуу аргачлал хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулах	-	Зарцуулсан эсэх: 0-зарцуулаагүй 1-зарцуулсан	0	1	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.3 дэх хэсэг, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, шийцэтгэх, үр дүнг тооцох журмын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 2 дугаар зүйлийн 2.1.6 дэх хэсэг 3 дугаар зүйлийн 3.2.18 дах хэсгийн дагуу “Геологи судалгааны ажлын 2022 оны аргачлал, хяналтын	100%	100%

							төлөвлөгөө, төсвийг боловсруулан, удирдлагад танилцуулан, 2022.05.02-ны өдрийн УУХҮСайдын “Журам шинэчлэн батлах тухай” А/87 дугаар тушаалын дагуу Үндэсний геологийн албаны даргын 2022.05.30-ны өдрийн А/15 дугаар тушаалыг гарган баталгаажуулж, дагаж мөрдөн ажилласан.		
56.	5.4.5	Геологийн судалгааны ажлын төсвийн зарцуулалтыг тайлагнах	-	Тайлагнасан эсэх: 0-үгүй 1-тийм	0	1	УУХҮСайдын Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулж, удирдлагад танилцуулан, Сангийн яаманд сар бүр, Үүнд: 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/56 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/93 04 дүгээр сарын 12-ны өдрийн 1/186 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/238 06 дугаар сарын 09-ний өдрийн 1/333 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/384 08 дугаар сарын 04-ний өдрийн 1/447 09 дүгээр сарын 02-ны өдрийн 1/503 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/540 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/602 12 дугаар сарын 09-ний өдрийн 1/660 дугаар албан бичгүүдээр гүйцэтгэлийг хүргүүлж, 1-12 дугаар сарын эрхийг нээлгэж, санхүүжилтийн 27,7 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор төсөл хэрэгжүүлэгч 56 аж ахуйн нэгжид санхүүжилтийг олгосон байна.	100%	100%
57.	5.4.6	Аргачлал хяналтын зардлаас санхүүжүүлэх худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТХ-д нийцүүлэн зохион байгуулах	-	Худалдан авалтыг хийсэн эсэх: 0-үгүй 1-тийм	0	1	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.8 дахь хэсэг, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, 46.1 дэх хэсэг, мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэг, УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/283 дугаар тушаал, Үндэсний геологийн албаны даргын 2022.02.11-ний өдрийн А/04 дүгээр тушаалын дагуу Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 14 багц Геологи судалгааны ажлын тендер зарлаж, шалгаруулан ажилласан.	100%	100%
58.	5.4.7	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн	-	Дүгнэсэн төслийн тоо	0	1	Үндэсний геологийн албаны даргын 2022.02.11-ний өдрийн А/04 дүгээр тушаалын дагуу Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих 2021 онд гэрээний	100%	90%

		судалгааны төслүүдийн гэрээг дүгнэх, гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх		нэмэгдсэн эсэх: 0-үгүй 1-тийм			хугацаа дуусгавар болох 14 төслөөс ЭБМЗ-өөр тайлан хэлэлцэгдсэн 6 төслийн гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулж, УУХҮЯ-нд албан бичгээр хавсралт материалуудын хамт илгээж, гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөх ажлыг зохион байгуулсан болно.		
59.	5.4.8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалыг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй геологийн судалгааны дууссан төслүүдийг биет бус хөрөнгөөр бүртгэж авах	-	Бүртгэсэн төслийн тоо нэмэгдсэн эсэх: 0-үгүй 1-тийм	0	1	Төсвийн тухай хуулийн 16 дугаар хуулийн 16.5.2, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, данснаас хасах, шилжүүлэх журмын"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн УУХҮЯ-ны ТНБД-ын 2022.01.04-ний өдрийн 03/09 дүгээр албан бичгийн дагуу төсөл хэрэгжүүлэгч 17 аж ахуйн нэгжийн 38,853.9 төгрөгийн санхүүжилтыг Үндэсний геологийн албаны балансад биет бус хөрөнгөөр бүртгэн авсан болно.	100%	100%
5.5. Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх									
60.	5.5.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх	-	Мэдээлэл сар бүр байршсан эсэх 0-Үгүй; 1-Тийм	0	1	УУХҮСайдын Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Геологи судалгааны ажлын гүйцэтгэлийг сар бүр хянан баталгаажуулж, удирдлагад танилцуулан, санхүүжилтийг дор бүр нь шийдвэрлэсэн. Геологи судалгааны ажлын санхүүжилт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээ тайлан, аудитлагдсан тайлан, аудитын гэрчилгээ, акт, албан шаардлага, бусад мэдээлэл Мэдээллийг шилэн дансанд тухай бүр нь байршуулж ажилласан.	100%	90%
61.	5.5.2	Төсвийн орлого болон зарлагын хэмжээ, хөрөнгө оруулалтыг тооцон, 2022 оны төсвийн тодотгол, 2023-2024 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх	-	Төсвийн төсөөлөл хүргэгдсэн эсэх: 0-Үгүй; 1-Тийм	0	1	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний геологийн албаны 2022 оны төсвийн төсөл, 2023-2025 оны төсвийн төсөөллийн саналыг боловсруулан хүргүүлсэн. 2023 оны төсвийн төсөл, 2023-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулахдаа Улсын төсөвт төвлөрүүлэх орлого, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, урсгал зардлыг Сангийн сайдын баталсан эдийн засгийн ангилал тус бүрээр тооцож, Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022.04.25-нд хүргүүлсэн.	100%	90%
62.	5.5.3	Байгууллагын архив байгуулах зураг	-	Хуульд заасны дагуу	0	1	Үндэсний геологийн албаны архив байгуулах зураг төслийг боловсруулж, бэлтгэл ажлуудыг	50%	50%

		төслийг боловсруулж, удирдлагад танилцуулж, тоног төхөөрөмжийн судалгаа гаргах, төсөв хөрөнгө шийдүүлэх		зохион байгуулсан эсэх 0-Үгүй; 1-Тийм			хийж гүйцэтгэх, холбогдох төсвийг боловсруулж, бэлэн болгосон. Өнгөрсөн 2 жилийн архивын материал хүлээн авч, хууль журамд заасны дагуу материалыг удаан хугацаагаар хадгалахад зориулалтын тавиур, шүүгээ болон, агаарын харьцангуй чийгшил 70-80% хүртэлх нөхцөлд удаан хугацаагаар хадгалах тохиолдолд хадгалалтыг хэвийн хэмжээнд байлгах зорилгоор эрчимтэй агааржуулах, салхилуулах зэрэгт дулаан хэмжигч /термометр, психрометр, гигрометр/-ийг халаалт, салхивчийн системээс хол, гол гарц дахь тавиурын хэсэгт байрлуулах зэрэг бүх арга, ажиллагаанд тодорхой хэмжээний төсөв хөрөнгө ихээр шаардлагатай. Уг ажлыг хэрэгжүүлэхээр архивын сан, байрны асуудал, зардал төсвийг тооцоолон гаргасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т зааснаар архив, бичиг хэрэгтэй холбоотой зардлуудыг бүрэн хориглосон болно. Ийнхүү архивын сан үүсгэх ажил Төрийн хэмнэлтийн хуулиар хойшлогдож, Үндэсний геологийн албанаас шалтгаалахгүй болсон болно.		
Зорилт 5.6. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх санал боловсруулах, тайлагнах, хариуцлага тооцох, урамшуулах, дотоодын хяналтын тогтолцоог сайжруулах, 2021 оны зорилтот түвшин, хүрсэн түвшний зөрүүг бууруулах									
63.	5.6.1	Агентлагийн хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэх	-	Хүргүүлсэн эсэх: 0-Үгүй; 1-Тийм	0	1	Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан шинээр батлагдсан Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмуудын хэрэгжилтийг нэгтгэн, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын журмын хүрээнд цаг хугацаанд нь нэгтгэн боловсруулж, удирдлагуудад танилцуулан, УУХҮЯ-нд албан бичгээр хүргүүлсэн. Нийт хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт-38 хууль, дүрэм журам.	100%	90%
64.	5.6.2	Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны	-	Хүргүүлсэн эсэх: 0-Үгүй; 1-Тийм	0	1	Үндэсний геологийн албаны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн боловсруулсан. Үүнд: - Шинэ сэргэлтийн бодлого,	100%	100%

		хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Хөтөлбөр төслүүдийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, УУХҮЯ-нд хүргүүлэх					- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, - Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөө Дээрх баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагуудад танилцуулан, УУХҮЯ-нд 2022.06.16-ны өдрийн 1/346 дугаар албан бичиг, 2022.12.15 өдрийн 1/669 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлэн, үр дүнг удирдах дээд байгууллагад танилцуулсан.		
65.	5.6.3	Агентлагийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэх	-	Хэрэгжсэн арга хэмжээний тоо:	56	66	Үндэсний геологийн албаны 2022 оны жилийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулж, удирдлагуудад танилцуулан, хянуулж, УУХҮЯ-нд 2022.06.16-ны өдрийн 1/346 дугаар албан бичиг, жилийн тайланг 2022.12.15-ны өдрийн 1/669 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн. Нийт 66 ажил арга хэмжээ төлөвлөж, 66 ажил арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн тайлагнаж, Үндэсний геологийн албаны гүйцэтгэлийн тайлангийн үр дүнг хүргүүлсэн болно.	100%	90%
66.	5.6.4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтүүдэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, хүргүүлэх	-	Биелэлт хангагдсан эсэх: 0-үгүй 1-тийм	0	1	УУХҮСайд, ТНБД-ын тушаалын биелэлтүүдийг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагуудад танилцуулан, УУХҮЯ-нд 2022.06.15-ны өдрийн 1/346 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны сүүлийн хагас жилийн УУХҮЯ-наас хагас жил тутамд ирүүлдэг УУХҮСайд, ТНБД-ын тушаал, албан даалгаврууд одоогоор ирээгүй байна. Ирсэн үед цаг хугацаанд нь хэрэгжилтээ хүргүүлэх болно.	100%	50%
Үнэлгээ								97.58%	91.2%

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж:
Дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн Б.Мөнхтуяа
Холбоо барих утас: 70181208
Цахим шуудан: b.munkhtuya@ngs.gov.mn